



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20~~22~~ оны 11 сарын 03-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Засаглалын бодлого батлах тухай

Говь ХК-ийн засаглалын бодлого, зорилго зорилт болон зарчмыг тодорхойлох зорилгоор Засаглалын бодлогыг батлах тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалтыг үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн “Засаглалын бодлого”-ыг Хавсралт-1 ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү бодлогыг үйл ажиллагаандаа тусган, зорилго зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн нийт гишүүд, Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/ нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ийн ДАРГА:



Д.ГЭРЭЛМАА

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
 2022 оны 11 сарын 03-ний өдрийн хурлын 23-р
 тогтоолын ... дүгээр хавсралт



ГОВЬ ХК-ИЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Дугаар:
 Б-ТУЗ-14-01



БАРИМТ БИЧГИЙН НЭР:

ГОВЬ ХК-ИЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

БАРИМТ БИЧГИЙН ХАРИУЦАГЧ	ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА		
БАРИМТ БИЧГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ	ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ-ИЙН ГИШҮҮД, НИЙТ АЖИЛТНУУД, БҮХ ОРОЛЦОГЧ ТАЛУУД		
БАТЛАГДСАН ОГНОО	2022.11.03		
БАРИМТ БИЧГИЙН НУУЦЛАЛЫН ЗЭРЭГЛЭЛ	НЭЭЛТТЭЙ	БАРИМТ БИЧГИЙН ТҮВШИН	T1

	АЛБАН ТУШААЛ	НЭР	ГАРЫН ҮСЭГ
БАТАЛСАН:	ТУЗ-ИЙН ДАРГА	Д.ГЭРЭЛМАА	
ХЯНАСАН:	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Ц.БААТАРСАЙХАН	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	М.БАЯР	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Ж.ОЮУНЧИМЭГ	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	А.ЖАРГАЛМАА	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Д.ХУЛАН	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Д.ХҮРЭЛБААТАР	

GOBI MONGOLIAN CASHMERE	ГОВЬ ХК-ИЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО	Дугаар: Б-ТУЗ-14-01
-----------------------------------	--------------------------------	------------------------

	ТХХ-ИЙН ДАРГА	Э.ИВГЭЭЛ	
БОЛОВСРУУЛСАН:	ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	М.СЭЛЭНГЭ	

Улаанбаатар хот
2022 он

	<p>ГОВЬ ХК-ИЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</p>	<p>Дугаар: Б-ТУЗ-14-01</p>
---	---------------------------------------	--------------------------------


Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл			
Хувилбарын дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо	Өөрчлөлт оруулж, боловсруулсан албан тушаалтан	Өөрчлөлтийн утга (баримт бичигт ямар өөрчлөлт орсныг товч тайлбарлана)
01	2022.11.03	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ	Баримт бичгийн анхны хувилбар

Баримт бичгийн төлөв		
Эх хувь	Албан хэрэгцээний хувь	Хүчингүй хувь
<div style="border: 1px solid red; padding: 5px; display: inline-block;"> <p style="text-align: center; color: red;">ГОВЬ ХК ЭХ ХУВЬ</p> <p>Гарын үсэг: <i>Анхууяла</i> 2022 он 11 сар 04 өдөр</p> </div>		

ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД		
№	Баримт бичгийн нэр	Бүртгэлийн дугаар
1	“Компанийн засаглалын кодекс”	Санхүүгийн зохицуулах хорооны 2022.03.23-ны №145 тогтоол
2	“Компанийн тухай хууль”	УИХ-ын 2011.10.06-ны хурлаар батлагдсан, сүүлд 2022.06.17-нд нэмэлт өөрчлөлт орсон
3	“Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”	УИХ-ын 2013.05.24-ний хурлаар батлагдсан, сүүлд 2022.06.17-нд нэмэлт өөрчлөлт орсон.
4	“Говь ХК-ийн дүрэм”	Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020.04.24-ний №02 тогтоол
5	Говь ХК-ийн “Тогтвортой хөгжлийн үүрэг амлалт”	Говь ХК-ийн ТУЗ-ийн 2022.04.19-ний №11 тогтоол
6	Говь ХК-ийн “Тогтвортой хөгжлийн бодлого”	Б-ТХХ-01-01
7	Говь ХК-ийн “Комплаенсын бодлого”	Б-ТХХ-07-01

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	5
1.1 Зорилго	5
1.2 Хамрах хүрээ	5
1.3 Нэр томъёоны тайлбар	5
2. БОДЛОГО	6
2.1 Засаглалын бодлого	6
2.2 Засаглалын зорилго, зорилт	6
3. МАНЛАЙЛАЛ БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА.....	11
3.1 Засаглалын бодлогын үүрэг, хариуцлага	11

	ГОВЬ ХК-ИЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО	Дугаар: Б-ТУЗ-14-01
---	--------------------------------	------------------------

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

1.1.1 Энэхүү Засаглалын бодлого (цаашид “Бодлого” гэх)-ын зорилго нь Говь ХК (цаашид “Компани” гэх)-ийн үйл ажиллагаандаа баримтлах засаглалын бодлого, зорилго зорилт болон зарчмыг тодорхойлох, компанийн засаглалын тогтолцоог бүрдүүлэгч оролцогч талуудын харилцааг цогцоор нь ханган, засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох оролцоог тодорхойлоход оршино.

1.2 Хамрах хүрээ

1.2.1 Энэхүү бодлого нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх), Гүйцэтгэх удирдлага, нийт ажилтнууд болон бусад оролцогч талуудад хамаарна.

1.2.2 Энэхүү бодлогыг Монгол улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон олон улсын засаглалын сайн туршлагуудын хүрээнд боловсруулж, компанийн хэмжээнд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, аливаа шийдвэр гаргалт болон засаглалын зорилтуудыг хэрэгжүүлэхдээ уг бодлогын зарчмыг баримтална.

1.3 Нэр томъёоны тайлбар

1.3.1 Уг бодлогын хүрээнд дараах нэр томъёог ашиглана.

1.3.1.1 **Компанийн засаглал:** Компанийн үйл ажиллагааг чиглүүлэх, хянах тогтолцоо бөгөөд байгууллагын зорилго, зорилтыг тодорхойлох, гүйцэтгэлийн хяналтын арга замыг тогтоох, хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо юм. Мөн энэ ойлголтод хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцаа;

1.3.1.2 **Засаглалын зарчим:** Компанийн засаглалын зорилтыг хэрэгжүүлэх, бодлого дүрэм журмыг боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны шатлал бүрд аливаа шийдвэрийг гаргахдаа баримтлах үндсэн үзэл баримтлал;

1.3.1.3 **Оролцогч талууд:** Компанийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, ажилтан, харилцагч, ханган нийлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, хэрэглэгч

үйлчлүүлэгч, санхүүжүүлэгч, малчид, олон нийт, төрийн байгууллага гэх мэт компанид сонирхол илэрхийлэгч бүх талууд;

- 1.3.1.4 **Компанийн засаглалын кодекс:** Компанид засаглалын зөв бөгөөд үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх, бүхий л оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлагыг нэвтрүүлэх, урт хугацаанд тогтвортой үнэ цэнийг бүтээхэд дэмжлэг үзүүлэх засаглалын зарчмууд;

2. БОДЛОГО

2.1 Засаглалын бодлого

- 2.1.1 Компанийн урт хугацааны хөрөнгө оруулалт, санхүүгийн тогтвортой байдал, бизнесийн тасралтгүй байдлыг хангахад шаардлагатай итгэлцэл, ил тод байдал, хариуцлагын орчныг бүрдүүлж, бүхий л оролцогч талын эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангасан шударга, ёс зүйтэй засаглалын тогтолцоог бүрдүүлнэ.

2.2 Засаглалын зорилго, зорилт


2.2.1 Оролцогч талуудын эрх ашгийг хангах

- 2.2.1.1 Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичгийг боловсруулж, оролцогч талуудын ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, зохистойгоор тэнцвэржүүлэн ажиллана.
- 2.2.1.2 Хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэн, тэдний эрхийг хамгаалж, эрхээ эдлэхэд нь туслалцаа үзүүлэхээс гадна бүх хувьцаа эзэмшигчдэд ижил тэгш хандана.
- 2.2.1.3 Хувьцаа эзэмшигч нартай харилцах хөтөлбөрийг боловсруулж хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудад мэдээлэл хүргэх цахим хуудсыг ажиллуулан, тогтмол мэдээллийг шинэчлэн ажиллана.
- 2.2.1.4 Оролцогч талуудаас өргөдөл, санал хүсэлтийг нь хүлээн авах, шийдвэрлэх зохистой тогтолцоог бүрдүүлнэ.

2.2.2 ТУЗ-ийн зохистой бүтэц зохион байгуулалтыг бүрдүүлэх

- 2.2.2.1 ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнийг олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, ёс зүйтэй манлайлал, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэцтэй байхаар бүрдүүлнэ.

- 2.2.2.2 Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах, засаглалыг бэхжүүлэх зорилгоор ТУЗ-ийн дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.
- 2.2.2.3 ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос гишүүдийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур үзүүлэлт, ТУЗ-ийн гишүүдийн санамж бичиг, залгамж халааны бодлогыг тодорхойлно.
- 2.2.2.4 ТУЗ-ийн зүгээс компанийн үйл ажиллагааг стратеги удирдлагаар хангаж, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд байнгын зохистой хяналтыг тавьж, хараат бус, бие даасан шийдвэрийг гаргана.
- 2.2.2.5 ТУЗ нь компани болон хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээж, тэдгээрийн эрх ашгийг хамгаална.
- 2.2.2.6 ТУЗ нь үйл ажиллагаагаа тодорхой чиг үүрэг хариуцсан Эрсдэл, аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ.
- 2.2.3 Тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг хангах**
- 2.2.3.1 Компанийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулах суурь болсон компанийн дотоод мэдээ мэдээллийн урсгалыг сайжруулж, аливаа мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв, оновчтой байдлаар ажилтнуудад хүргэх боломжийг бүрдүүлнэ.
- 2.2.3.2 Компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагаа, өмчлөл, засаглалтай холбоотой болон хууль, дүрэм журамд заасан бусад мэдээллүүдийг цаг хугацаанд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд байдлаар хувьцаа эзэмшигчид болон олон нийт, холбогдох эрх бүхий байгууллагад мэдээлнэ.
- 2.2.3.3 Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангахдаа санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл, тайлагналын тэнцвэртэй байдлыг хангана.
- 2.2.3.4 Олон нийтэд хүргэх мэдээллийн агуулга, мэдээлэл түгээх сувгийг тасралтгүй сайжруулна.
- 2.2.4 Шударга, ёс зүйтэй үйл ажиллагааг явуулах**
- 2.2.4.1 Үйл ажиллагаандаа Монгол улсын болон олон улсын хууль, дүрэм журмуудыг дагаж мөрдөн, ёс зүйтэй бизнесийн орчныг бүрдүүлнэ.

	ГОВЬ ХК-ИЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО	Дугаар: Б-ТУЗ-14-01
---	--------------------------------	------------------------

- 2.2.4.2 Компанийн нийт ажилтнуудын баримтлах ёс зүйн тулгуур зарчмуудыг тодорхойлон, баталж, өдөр тутмын үйл ажиллагаанд нь хэвшүүлнэ.
- 2.2.4.3 Ёс зүйн зөрчлийг мэдээлэх, хүлээн авах, шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх зохистой бөгөөд шударга тогтолцоог бүрдүүлж, шүгэл үлээх системийг хэрэгжүүлнэ.
- 2.2.4.4 Компанийн эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлж, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг боловсруулан хэрэгжилтийг ханган, үр дүнгээ хувьцаа эзэмшигчдийн хуралд тогтмол танилцуулна.

2.2.5 Хяналтын тогтолцоог бүрдүүлэх

- 2.2.5.1 ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь компанийн хэмжээнд эрсдэлийн удирдлага, аудит, хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлэх, түүний үр дүнтэй байдал болон хэрэгжилтэд хяналт тавина.
- 2.2.5.2 Компани нь дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэхдээ “Хамгаалалтын 3 шугам” загварын дагуу зохион байгуулалтыг хийнэ.
- 2.2.5.3 ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны харьяалалд Дотоод аудитын хэлтэс компанийн хэмжээнд хараат бус, бие даасан байдлаар 3-р шугамын хяналтыг хэрэгжүүлнэ.
- 2.2.5.4 Гүйцэтгэх удирдлага нь компанийн хэмжээнд эрсдэлийн удирдлага, комплаенс, санхүү, үйл ажиллагааны дотоод хяналтын зохистой бүтцийг бүрдүүлж, 1,2-р шугамын хяналтыг хэрэгжүүлэн, эрсдэлийг тогтмол удирдан ажиллана.

2.2.6 Компанийн соёлыг төлөвшүүлэх

- 2.2.6.1 Компанийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс болон уриа үгийг оновчтой тодорхойлж, түүнийг нийт ажилтнуудад таниулан, өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлэх замаар байгууллагын соёлыг бэхжүүлнэ.
- 2.2.6.2 Ажилтнуудын санал санаачилга, бүтээлч сэтгэлгээг дэмжих, хамтран ажиллах соёлыг төлөвшүүлж, бүх нийтийн оролцоог хангана.

2.2.6.3 ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь бүхий л оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.

2.2.7 Цалин урамшууллын зохистой системийг бүрдүүлэх

2.2.7.1 ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо нь компанийн хэмжээнд цалин урамшууллын зохистой тогтолцоог бүрдүүлэх, түүний үр дүнтэй байдал болон хэрэгжилтэд хяналт тавина.

2.2.7.2 Цалин урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг компанийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан оновчтой тодорхойлно.

2.2.7.3 Компанийн хэмжээнд ажилтнуудыг өсч дэвжих боломжоор хангасан шударга, үр дүнтэй цалин урамшууллын тогтолцоог бүрдүүлэх бөгөөд цалин урамшууллын зах зээлийн судалгаа болон эдийн засгийн нөхцөл байдлын судалгааг тогтмол хийн цалин урамшууллын хэмжээг зах зээлд өрсөлдөхүйц хэмжээнд тогтооно.

2.2.7.4 Эрх бүхий албан тушаалтнуудын цалин урамшууллыг тогтоохдоо гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, бүрэлдэхүүн нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байх үндсэн зарчмыг баримтална.

2.2.7.5 ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар нээлттэй хэлэлцэж батална.

2.2.8 Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг хөгжүүлэх

2.2.8.1 ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын зүгээс тогтвортой хөгжлийн үүрэг амлалт, бодлого, зохицуулалтын дүрэм журмыг боловсруулан, компанийн хэмжээнд тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд манлайлж оролцоно.

2.2.8.2 Байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд олон улсын сайн туршлагыг судлан хэрэгжүүлж, үйлдвэрлэл болон үйл ажиллагааны шат дамжлага бүрдээ тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тусган ажиллана.

2.2.8.3 Компанийн үйл ажиллагааны бүтээмжийг тогтмол сайжруулах зорилгоор шинэ мэдлэг мэдээлэл, ногоон технологи болон судалгаа хөгжүүлэлтийг дэмжин ажиллана.

2.2.8.4 Нэгдсэн удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг дэмжсэн менежментийн аргачлалуудыг хэрэгжүүлнэ.

2.2.8.5 Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагаагаа жил бүр үнэлэн тайлан бэлтгэж, олон нийтэд мэдээлэхээс гадна тайлангийн үр дүнд үндэслэн тогтвортой хөгжлийн үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулна.

2.2.9 Компанийн засаглалыг тасралтгүй сайжруулах

2.2.9.1 “Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр”-ийг тодорхойлон баталж, хэрэгжүүлэн ажиллана.

2.2.9.2 Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг Монголын хөрөнгийн биржээс баталсан үнэлгээний аргачлалын дагуу жил бүр үнэлэн, тайлан бэлтгэж олон нийтэд мэдээлэхээс гадна тайлангийн үр дүнд үндэслэн засаглалын тогтолцоо, үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулна.

2.3 Засаглалын зарчим

2.3.1 **Ил тод байдлыг хангах:** Үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг эрхэмлэн, гадаад болон дотоод сонирхогч талуудыг үнэн зөв мэдээллээр цаг хугацаанд нь ханган ажиллана.

2.3.2 **Бүх оролцогч талын эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангах:** Үйл ажиллагаа явуулах, аливаа шийдвэрийг гаргахдаа бүхий л оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн үзэж, тэнцвэртэй байдлыг хангана.

2.3.3 **Хууль, дүрэм журмыг мөрдөх:** Үйл ажиллагааны шат бүртээ хууль, дүрэм журмыг мөрдөн, хэрэгжилтийг ханган ажиллана.

2.3.4 **Шударга, ёс зүйтэй байх:** Компанийн эрх ашгийг хувийн эрх ашгаас ямагт дээгүүр тавьж, ёс зүйн зарчмыг баримтлан ажиллана.

2.3.5 **Хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх:** Компанийн хэмжээнд хяналт болон хариуцлагын зохистой тогтолцоог бүрдүүлэн, эрсдэлийг урьдчилан тодорхойлж, удирдах арга хэмжээг авч ажиллана.

2.3.6 **Байгууллагын соёлыг төлөвшүүлэх:** Компанийн алсын хараа, эрхэн зорилго, үнэт зүйлс дээр тулгуурласан шийдвэр гаргалт, харилцааны зарчмыг баримтлан, бүх нийтийн идэвх, оролцоог хангасан соёлыг төлөвшүүлнэ.

- 2.3.7 **Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх:** Аливаа шийдвэр гаргалт болон бизнесийн үйл ажиллагааны процесс бүртээ тогтвортой хөгжлийн үүрэг амлалт, бодлого, зорилго зорилтыг шингээнэ.
- 2.3.8 **Тасралтгүй сайжруулах:** Засаглалын тогтолцоо, үйл ажиллагаа, бодлогын баримт бичиг болон зарчмуудаа олон улсын жишиг, хэм хэмжээнд нийцүүлэн тасралтгүй сайжруулан ажиллана.

3. МАНЛАЙЛАЛ БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

3.1 Засаглалын бодлогын үүрэг, хариуцлага

Хүснэгт 1 Засаглалын бодлогын үүрэг, хариуцлагын матриц

Процесс	Оролцогч талууд	ТУЗ	Менежмент баг	ТУЗ-ийн ажлын алба
<i>Л-гүйцэтгэх, Х-хариуцах, З-зөвлөлдөн хамтран ажиллах, М-мэдээлэл авах/</i>				
Засаглалын бодлогыг боловсруулах, батлах	М	Х, Г	З, М	Г
Засаглалын бодлогыг оролцогч талуудад түгээх, мэдээллээр хангах	М	З, М	М	Х, Г
Засаглалын бодлогыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх	М	Х, Г	Г	Г
Засаглалын бодлогыг хэрэгжүүлэхэд арга зүйгээр хангах	М	З, Г	М	Х, Г
Засаглалын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, сайжруулах	М	Х, Г	М	Г
Шаардлагатай тохиолдолд шинэчлэх	М	Х, Г	З, М	Г

- 3.1.1 ТУЗ нь Засаглалын бодлогыг баталж, тус бодлогын дагуу компанийн стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд засаглалын зорилго, зорилтуудыг тусгах, бизнесийн үйл явцад нэгтгэх, төлөвлөсөн үр дүнд хүрэх нөхцөлөөр хангана.
- 3.1.2 ТУЗ нь Засаглалын бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, засаглалын зорилго, зорилтын хэрэгжилтийг үнэлэн, тасралтгүй сайжруулах бөгөөд шаардлагатай тохиолдолд шинэчлэн батална.

- 3.1.3 Менежмент багийн удирдлагууд нь Засаглалын бодлого, зорилтыг хэрэгжүүлж, байнгын сайжруулалтыг дэмжин, үр нөлөөтэй байдлыг ханган, засаглалын зарчмуудыг баримтлан ажиллана.
- 3.1.4 ТУЗ-ийн ажлын алба нь Засаглалын бодлого, зорилтыг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангахад манлайлан оролцох, ТУЗ болон Менежмент багийг арга зүйгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих, тасралтгүй сайжруулах үүргийг хүлээх бөгөөд оролцогч талуудыг мэдээллээр ханган ажиллана.

ТӨГСӨВ.



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 11 сарын 03 ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

**Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх
хөтөлбөр батлах тухай**

Говь ХК-ийн засаглалын бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг тодорхойлох зорилгоор хөтөлбөр боловсруулан батлах тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалтыг үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр”-ыг Хавсралт-1 ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү хөтөлбөрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн нийт гишүүд, Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/ нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Ж.ОЮУНЧИМЭГ

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР



**ГОВЬ ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР**

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

1.1.1. Энэхүү Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийн зорилго нь Говь ХК (цаашид “Компани” гэх)-ийн засаглалын бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг тодорхойлоход оршино.

1.2 Хамрах хүрээ

1.2.1. Энэхүү хөтөлбөр нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх), Гүйцэтгэх удирдлага, нийт ажилтнууд болон бусад оролцогч талуудад хамаарна.

1.3 Нэр томъёоны тайлбар

- 1.3.1. **Компанийн засаглал:** Компанийн үйл ажиллагааг чиглүүлэх, хянах тогтолцоо бөгөөд байгууллагын зорилго, зорилтыг тодорхойлох, гүйцэтгэлийн хяналтын арга замыг тогтоох, хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо юм. Мөн энэ ойлголтод хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцаа багтана.
- 1.3.2. **Засаглалын зарчим:** Компанийн засаглалын зорилтыг хэрэгжүүлэх, бодлого дүрэм журмыг боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны шатлал бүрд аливаа шийдвэрийг гаргахдаа баримтлах үндсэн үзэл баримтлалыг хэлнэ.
- 1.3.3. **Оролцогч талууд:** Компанийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, ажилтан, харилцагч, ханган нийлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, хэрэглэгч үйлчлүүлэгч, санхүүжүүлэгч, малчид, олон нийт, төрийн байгууллага гэх мэт компанид сонирхол илэрхийлэгч бүх талуудыг хэлнэ.
- 1.3.4. **Компанийн засаглалын кодекс:** Компанид засаглалын зөв бөгөөд үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх, бүхий л оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлагыг нэвтрүүлэх, урт хугацаанд тогтвортой үнэ цэнийг бүтээхэд дэмжлэг үзүүлэх засаглалын зарчмуудыг хэлнэ.

1.3.5. **Эрх бүхий албан тушаалтан:** ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн гишүүд, компанийн Гүйцэтгэх захирал, Дэд захирлууд, Газрын захирлууд, Хуулийн зөвлөх, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг хэлнэ.

1.4. Эрх, үүргийн матриц

Хүснэгт 1 Хөтөлбөрийн эрх үүргийн матриц

Процесс	Оролцогч талууд	ТУЗ	Менежмент баг	ТУЗ-ийн ажлын алба
<i>/Г-гүйцэтгэх, Х-хариуцах, З-зөвлөлдөн хамтран ажиллах, М-мэдээлэл авах/</i>				
Хөтөлбөрийг боловсруулах, батлах	М	Х, Г	З, М	Г
Хөтөлбөрийг оролцогч талуудад түгээх, мэдээллээр хангах	М	З, М	М	Х, Г
Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, батлах	М	Х, Г	Г	Г
Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд арга зүйгээр хангах	М	З, Г	М	Х, Г
Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, тайлагнах	М	Х, Г	М	Г

- 1.4.1. Хөтөлбөрийг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс” болон компанийн Засаглалын бодлогын хүрээнд ТУЗ-ийн ажлын албанаас боловсруулан, ТУЗ-өөс батална.
- 1.4.2. ТУЗ нь хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн удирдлагаар ханган, тогтмол хяналтыг тавих бөгөөд хэрэгжилтийн үнэлгээг баталгаажуулан тайлагнана.
- 1.4.3. ТУЗ-ийн ажлын алба нь хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад арга зүйгээр ханган бодлогын баримт бичгүүдийг боловсруулах бөгөөд уг хөтөлбөрийн үнэлгээ, тайланг бэлтгэн, оролцогч талуудыг мэдээллээр ханган ажиллана.
- 1.4.4. Менежмент багийн удирдлагууд нь хөтөлбөрийн хүрээнд бодлогын баримт бичгүүдийг боловсруулахад чиг үүргийнхээ хүрээнд хамтран ажиллах бөгөөд үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, компанийн хэмжээнд хэвшүүлэхэд манлайлан оролцоно.

2. ХӨТӨЛБӨР

2.1 Хөтөлбөрийн зорилт

- 2.1.1. Компанийн засаглалын бодлогын зорилго зорилтын хэрэгжилтийг хангах;

- 2.1.2. Хувьцаа эзэмшигчийн эрхийг баталгаажуулах;
- 2.1.3. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын хариуцлагын тогтолцоог олон улсын жишигт хүргэх;
- 2.1.4. Тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах;
- 2.1.5. Эрсдэлийн удирдлагыг сайжруулах;
- 2.1.6. Хяналтын тогтолцоог сайжруулах.

2.2 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 2.2.1 Компанийн тухай болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, “Компанийн засаглалын кодекс”-т тусгагдсан бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг компанийн засаглалын үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн боловсруулан батлах, мөрдүүлэх;
- 2.2.2 Компанийн бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд комплаенсын хяналтыг тогтмол хэрэгжүүлэх;
- 2.2.3 Эрх бүхий албан тушаалтнуудыг компанийн засаглалын сургалтад хамруулах;
- 2.2.4 Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, мэдээлэх.

2.3 Хөтөлбөрийн зохион байгуулалт

- 2.3.1 ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь дараах чиглэлээр бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг баталж, мөрдөх бөгөөд хэрэгжилтэд нь хяналт тавина.

№	Баримт бичгийн нэр	Батлах хэлбэр	Хугацаа
1	Шинээр батлах бодлогын баримт бичиг, дотоод журмууд:		
1.1	Засаглалын бодлого	Шинээр батлах	2022 оны 4-р улирал
1.2	Олон нийтэд хүргэх мэдээллийн журам	Шинэчлэх	2022 оны 4-р улирал
1.3	Оролцогч талуудын өргөдөл, санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам	Шинэчлэх	2022 оны 4-р улирал
1.4	Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам	Шинэчлэх	2022 оны 4-р улирал
1.5	Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам	Шинэчлэх	2022 оны 4-р улирал
1.6	Эрх бүхий албан тушаалтны залгамж халааны бодлого	Шинэчлэх	2023 оны 1-р улирал
1.7	ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур, ТУЗ-ийн гишүүдийн санамж бичиг	Шинээр батлах	2023 оны 1-р улирал

1.8	Эрсдэл, аудитын хорооны дүрэм	Шинэчлэх	2023 оны 2-р улирал
1.9	Нэр дэвшүүлэх хорооны дүрэм	Шинэчлэх	2023 оны 2-р улирал
1.10	Цалин, урамшууллын хорооны дүрэм	Шинэчлэх	2023 оны 2-р улирал
1.11	Нийгмийн хариуцлагын бодлого	Шинээр батлах	2023 оны 2-р улирал
1.12	Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал, байгаль орчны бодлого	Дахин хянаж, хэлэлцэн шийдвэр гаргах	2023 оны 2-р улирал
1.13	Компанийн цалин, урамшууллын бодлого	Шинэчлэх	2023 оны 3-р улирал
1.14	Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам	Шинэчлэх	2023 оны 3-р улирал
1.15	Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого	Шинээр батлах	2023 оны 3-р улирал
2	Үргэлжлүүлэн мөрдөх бодлогын баримт бичиг, дотоод журмууд:		
2.1	Ёс зүйн код	Шинэчлэгдэн батлагдсан	2022.08.05
2.2	Эрсдэлийн удирдлагын бодлого	Шинэчлэгдэн батлагдсан	2020.06.22
2.3	Дотоод хяналтын бодлого	Батлагдсан	2021.10.26
2.4	Дотоод аудитын дүрэм	Шинэчлэгдэн батлагдсан	2018.10.03
2.5	Тогтвортой хөгжлийн үүрэг амлалт	Батлагдсан	2022.04.19
2.6	Тогтвортой хөгжлийн бодлого	Батлагдсан	2022.07.08
2.7	Комплаенсын бодлого	Батлагдсан	2022.04.04
2.8	Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны бодлого	Батлагдсан	2022.06.06
2.9	Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам	Шинэчлэгдэн батлагдсан	2021.04.16
2.10	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	Шинэчлэгдэн батлагдсан	2022.08.05
2.11	ТУЗ-ийн ажлын албаны журам	Шинэчлэгдэн батлагдсан	2022.08.05
2.12	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам	Батлагдсан	2021.09.27
2.13	Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны бодлогын журам	Батлагдсан	2021.09.27
2.14	Хөндлөнгийн аудит томилох журам	Батлагдсан	2021.09.27

3. ҮНЭЛГЭЭ, ТАЙЛАГНАЛ

3.1 Үнэлгээ

3.1.1 ТУЗ-ийн ажлын алба нь дараах үнэлгээ, тайланг жил бүрийн эцэст хийн, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулна. Үүнд:

3.1.1.1 Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулсан үнэлгээний аргачлалын дагуу үнэлсэн “Засаглалын тайлан”;

3.1.1.2 Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан.

3.2 Тайлагнал

3.2.1. ТУЗ нь “Засаглалын тайлан” болон энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, явцын талаар жилийн үйл ажиллагааны тайланд тусган, Монголын хөрөнгийн бирж болон компанийн цахим хуудсанд байршуулахаас гадна хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

3.2.2. ТУЗ-ийн ажлын алба нь энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалын хамт Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

ТӨГСӨВ.